

**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
ТҮҮНД ӨГӨХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ**

***Нэг. Уулын үйлдвэрлэл, технологийн талаар***

2014 оны гүйцэтгэлээр 6,774.8 мянган.м<sup>3</sup> хөрс хуулж (тээвэртэй 5,368.5 м.м<sup>3</sup>, тээвэргүй 1,406.3 м.м<sup>3</sup>) 1,939.1 мянган тонн нүүрс олборлон 2,013.7 мянган тонн нүүрс борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөө 82.1 хувь, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөө 97.0-100.7 хувийн биелэлттэй байна. Тээвэртэй хөрс хуулалт 100.3 хувь, тээвэргүй хөрс хуулалт 48.0 хувийн тус тус биелэлттэй байна

Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт, борлуулалтын хэмжээ 98.7-105.0 хувийн, хөрс хуулалт 95.9 хувийн гүйцэтгэлтэй, нийт уулын цулын хэмжээ 7.2 хувиар өссөн байна.

Нүүрс борлуулалтын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 0.7 хувь буюу 13.7 мянган тонноор, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.0 хувь буюу 96.7 мянган тонноор тус тус давж биелсэн юм.

***Тээвэртэй хөрс хуулалт:*** Баруун жигүүрт алхагч экскаваторын 2014, 2015 оны ажлын фронт бэлтгэн 5 доголд тээвэртэй хөрс хуулах төлөвлөгөөтэй ажилласан. Төлөвлөгдсөн ажлаас дээд талын 3 доголын хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж дууссан ба тээврийн хэрэгслийн зогсолт, саатал их /ТАК-0,68/, хүрэлцээ муугаас 4 болон 5 дахь суултын хөрсний ажил дутуу хийгдсэн. Энэ нь 2015 оны тээвэргүйгээр хөрс хуулж нүүрс нээх ажлын фронтыг 3 сараар хоцрогдуулах нөхцлийг үүсгээд байна. 2014 оны тээвэртэй хөрс хуулалтыг 23 технологийн автомашинаар гүйцэтгэх байсан боловч хоногт дунджаар 13-15 машин ажилд гарч, төлөвлөсөн хэсгийн хөрсийг хуулж амжихгүй байдалд хүрсэн. Иймд 8-р сарын 06-ны өдрөөс 11-р сарын 17-ны хооронд түрээсийн ачиж, тээвэрлэх компанийг оруулж ажилласнаар 1038,6 мян м<sup>3</sup> хөрсний ажлыг гүйцэтгүүлж тээвэртэй хуулах хөрсний төлөвлөгөөг биелүүлсэн.

***Тээвэргүй хөрс хуулалт:*** 2014 онд ЭШ-25/90 алхагч экскаватораар нүүрс нээх ажлыг гүйцэтгэж, тооцооны 0-40-р огтлолын хооронд хөрс хуулсан. Хөрсний дотоод овоолго нүүрс олборлосон хоосон орон зай руу түрж, гулссаны улмаас хуулсан хөрсний овоолгыг дахин шидэж зайлуулах ажил хийгдэж байсны улмаас хөрсний ажил хоцрогдон, шидэлтийн ажил нэмэгдсэн. Тээврийн хэрэгслийн хүрэлцээ муу байснаас үндсэн завсрын хөрсний ажил удааширч нүүрс нээгдэх, олборлох байдал хоцрогдох хүндрэл үүссэн. Үүнтэй уялдуулж алхагч экскаваторын хуулах хөрсийг мостны баруун талын тооцооны 40-50-р огтлолын хооронд тээвэргүйгээр хуулах хөрсийг түрээсийн ачиж, тээвэрлэх компанийг оруулж 2-р давхаргын нүүрсийг нээж ажилласан.

***Нүүрс олборлолт, борлуулалт***

2013-2014 онд складанд 279,3 мян.тн, уурхайн ашиглалтын 3-р аманд 100.0 мян тн, 2-р аманд 400.0 мян.тн, 1-р аманд 50.0 мян.тн нүүрсний нөөцтэй шилжсэн. 2014 оны 12-р сарын 01-ны байдлаар ашиглалтын 2, 3-р амны нүүрсийг бүрэн олборлосон. Нүүрс олборлолтын үед дотоод овоолгын гулсалт, гүний усны хүндрэлүүд гарч ажил гүйцэтгэхэд бэрхшээлтэй байсан.

2014 онд 2000,0 мян.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажилласан. "ДЦС-IV" ТӨХК нь 1750.0 мян.тн, бусад орон нутгийн хэрэглэгчдэд 250 нүүрс тус тус борлуулах байсан. 2014 онд "ТЭЦ-4" ТӨХК-нд 1851,2 мян тн, бусад орон нутгийн ДЦС, хэрэглэгчдэд 159,9 мян.тн нүүрс нийлүүлж төлөвлөгөөгөө биелүүлсэн.

**Өрөмдлөг тэсэлгээний ажил:** 2014 оны өрөмдлөг тэсэлгээний ажлын төлөвлөгөөнд 159.3 мян.у/м өрөмдөж 40.0 тн эмульсын тэсрэх бодис, 1729.1 тн ЭТБ /ANFO/ хэрэглэж 4608.9 мян.м3 уулын цул тэсэлж сийрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2014 онд 16.4 мян.ш цооногийг 117.4 мян.у/м өрөмдөж 2852.1 мян.м3 уулын цулыг 156.2 тн эмульсын тэсрэх бодис, 1561.6 тн ЭТБ-оор 278 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна.

- Тээвэргүй хөрсөнд 5.4 мян.у/м өрөмдлөгийн ажил хийж 276.2 мян.м3 уулын цулыг тэсэлж сийрэгжүүлсэн. ЭШ-11/70 алхагч экскаваторын угсралтын ажил 07-р сарын 01-нд дуусаж хөрс хуулалтанд орно гэж төлөвлөж байсан боловч 09-р сарын 15-нд дууссан ба техникийг жигдрүүлэхийн тулд дахин шидэлтийн ажил гүйцэтгүүлж, 11-р сарын 20-ноос хөрс хуулалтын ажил хийж эхлэсэн. ЭШ-25/90 алхагч экскаваторын тэслэгдэх уулын цул нь дулааны улирал, чулуулгийн шинж чанараас хамаарч тэслэх хувь хэмжээ 30%-иар буурсан. Тухайн алхагч экскаваторуудын нөхцөл байдал нь өрөмдлөг тэсэлгээний ажлын хүлээгдэл, хэмнэлт гарах үндсэн шалтгаан болсон.
- Тээвэргүй хөрсөнд 5.4 мян.у/м өрөмдлөгийн ажил хийж 276.2 мян.м3 уулын цулыг тэсэлж сийрэгжүүлсэн. ЭШ-11/70 алхагч экскаваторын угсралтын ажил 07-р сарын 01-нд дуусаж хөрс хуулалтанд орно гэж төлөвлөж байсан боловч 09-р сарын 15-нд дууссан ба техникийг жигдрүүлэхийн тулд дахин шидэлтийн ажил гүйцэтгүүлж, 11-р сарын 20-ноос хөрс хуулалтын ажил хийж эхлэсэн. ЭШ-25/90 алхагч экскаваторын тэслэгдэх уулын цул нь дулааны улирал, чулуулгийн шинж чанараас хамаарч тэслэх хувь хэмжээ 30%-иар буурсан. Тухайн алхагч экскаваторуудын нөхцөл байдал нь өрөмдлөг тэсэлгээний ажлын хүлээгдэл, хэмнэлт гарах үндсэн шалтгаан болсон.
- Нүүрсэнд 46.1 мян.у/м өрөмдлөг хийж 1164.1 мян.м3 уулын цулыг тэсэлж сийрэгжүүлсэн. Уурхайн олборлолт явагдаж буй хэсгүүдийн гүний усны усжилтын байдлаас шалтгаалан усны түвшинг бууруулах зорилгоор тэсэлгээний ажил тодорхой хэмжээгээр хийгдсэн нь төлөвлөгөөнөөс давах үндсэн нөхцөл болж байна.

**Ус шүүрүүлэлтийн ажил:** Ус шүүрүүлэх хэсэг нь 2014 онд А, В, С шугам болон карьерт нийт 29 цооног ажиллаж 3159.5 сая.м3 ус уурхайгаас зайлуулж усны түвшинг 3.56 м-ээр буулгаад байна.

Цаашид туршилт судалгааны ажлыг шаардлагтай нөхцөл байдал үүссэн бүрд нь үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна. Төлөвлөгөөний дагуу нийт 32 худагт засвар үйлчилгээ, дулаалга, шугамуудын даланг сэргээн засварлан бэлэн байдлыг хангаад байна.

## 2014 онд шавхсан усны хэмжээ, цооног ашиглалтын мэдээ

Цооног	2014 оны 12-р сарын 31 ны байдал				
	Ажилласан цоонгийн дундаж	Мото цаг	Цахилгааны саатал /цаг/	Засвар /цаг/	Шахсан ус /м3/
А-шугам	8	41347.5	630	1137	948245
В-шугам	11	72689	1006	917	1161928
С-шугам	11	70945.5	999.5	1379	1307617
К-шугам	1	3137	27	75	899816
Дүн	30	188119	2662	3496	4317605

## Усны түвшингийн мэдээ

Ашиглалтын ам	2013.12.30	2014.12.01	Бууралт зөрүү
I ам	1125.08	1125.38	0,30
II ам	1125.64	1125.68	0,04
Дундаж	1125.57	1125,53	-0,04

**ХОЁР. Компаний техникийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд**

Компанийн техникийн бүрэлдэхүүнийг уул уурхайн зориулалт бүхий өндөр бүтээлт уулын болон тээврийн хэрэгслүүдэд шилжүүлэх парк шинэчлэлтийг эхлүүлж, борлуулалтын дараах үйлчилгээ болон засвар үйлчилгээний зардлууд, ашиглалтын явц дахь зардал, сэлбэг хэрэгслийн нийлүүлэлт зэрэг үйлчилгээ, нөхцлүүдийг харгалзан парк бүрдүүлэлтийг нэг төрлийн буюу нэг улс, брендийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээр хийх бодлогыг баримтлан ажиллаж байна.


Олон утгуурт экскаватор, хөрс тээврийн тасралтгүй ажиллагаатай конвейер овоолого үүсгэгч зэргээс бүрдсэн "Тасралтгүй үйл ажиллагааны систем"ийг нэвтрүүлэх төсөл боловсруулж ТУЗ-д танилцуулж дэмжигдэн, санхүүгийн эх үүсвэр шийддэгдсэн тохиолдолд хэрэгжүүлж эхлэхэд бэлэн болгоод байна.

ОХУ-ын БЕЛАЗ-7555В маркийн автосамосвал, 10-15 м3 экскаваторын техникийн холбогдолтой мэдээллийг боловсруулсан судалгаа хийсэн.


1. Нүүрс бутлан ачиж борлуулах, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор ТДХ-ийн вагон түлхэгчийг шинээр суурилуулж ашиглалтанд оруулсан.

2. Үйлдвэрлэлийн ба иргэний барилга, цахилгаан хангамж болон инженерийн байгууламж, бусад өргөтгөл засварын талаар 10 гаруй барилга угсралтын ажлыг 136,74 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.


Хөрсний машины хувьд




Нүүрсний машины хувьд




Хүнд машин механизм хувьд



Цахилгаан экскаватор



Өрмийн машин



Уул тээврийн машин механизм, тоног төхөөрөмжийн насжилт өндөр болсноос тэдгээрийн найдвартай ажиллагаа буурч байгаа бөгөөд цаашид техникийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлага гарч байна.

Техникийн шинэчлэл хийх зорилгоор судалгаа, техникийн тодорхойлолт гарган ОХУ-ын БЕЛАЗ-7555В маркийн автосамосвал 4, ЭШ-11/70 алхагч экскаватор 1, тусгай зориулалтын вышкатай автомашин 1, тэсэлгээний цооног цэнэглэгч автомашин 1 гээд нийт 4,850,454 мянган төгрөгийн үнэ бүхий 7 техник тоног төхөөрөмжийг 2014 оноос шинээр ажилд оруулаад байна.

Сүүлийн 5 жилд машин, тоног төхөөрөмжийн эвдрэлтэй холбоотой Техникийн төв комиссын актаар тавьсан төлбөрийн хэмжээг дараах хүснэгтэд харуулав.

№	Актууд	Хэмжих нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он
1.	Нийт шийдвэрлэсэн актууд	Ш	305	315	481	514
2.	Төлбөргүй актууд	Ш	258	288	449	497
3.	Төлбөртэй актууд	Ш	47	24	32	17
4.	Хариуцагчдад тавьсан төлбөрийн хэмжээ	мян.төг	19772.0	14709.8	18068.9	9361,0

## ГУРАВ. Компанийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн талаар

“Шивээ-Овоо” ХК нь 2014 онд төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрээр компанийн бүтэц 6 хэлтэс, 2 алба, 8 хэсэг, 1 охин компани, Ажиллах хүчний орон тоо 538 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулахаар батлагдан ажилласан байна.

Компанийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд 7 хоног бүрийн 1 дэх өдөр Гүйцэтгэх захирлын нэгдсэн наряд, 5 дахь өдөр Захирлын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, 7 хоног, сарын хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэж, ажлын тодорхой чиглэл, үүрэг даалгаврыг өгч ирсэн. Өнгөрсөн онд Захирлын зөвлөлийн гишүүдэд болоод ерөнхий мэргэжилтнүүд, алба, хэсгийн дарга нарт нийт 1614 наряд, үүрэг даалгавар өгсөнөөс 1549 буюу 96.0 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн байна. Компанийн захирлын зөвлөлийн хурлыг 28 удаахуралдаж, 369 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

2014 онд байнгын ажлын байранд нийт 57 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ шинээр байгуулсан нь өнгөрсөн оныхоос 39 хүнээр буюу 40%-иар буурсан, мөн онд 49 ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ цуцалсан нь 2013 оныхоос 22 ажилтан буюу 31 %-иар буурсан юм. Түүнчлэн 2014 онд сахилгын зөрчил 47 гарсан нь өнгөрсөн оныхоос 9 буюу 27 %-иар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2014 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж түүний хүрээнд АЗДТГазрын нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Х.Баяржаргалыг урьж, нийт уурхайчдад гэр бүл төлөвшилтийн лекц, сумын цагдаагийн хэсэгтэй хамтарч 8 удаа орон нутагт гарч байгаа хэрэг зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх арга зам сэдвээр мэдээлэл хийлгэсэн. Мөн “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг өөрөөсөө эхлэх нь” уриалга гаргаж нийтээр амрах баярын өдрүүдэд болон сар бүрийн 10, 20-ны өдрүүдэд төлөвлөгөөт график гарган энгийн ажилчдаас эхлэн удирдах албан тушаалтан бүрийг хамруулан хариуцлагатай эргүүл болон хөдөлгөөнт эргүүлийн ажлыг хийж, үр дүнг нь тооцож ажиллаж байна. Энэ ажилдаа ахмадын зөвлөл болон охин компани болох “Шивээ Сервис” ХХК-ийн ажилчдыг мөн хамруулж зохион байгуулж байна.

Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гарын авлага эмхэтгэл гаргаж, хэлтэс, алба, хэсэг нэгжийн удирдлагаар дэмжуулан нийт ажилчдад таниулга хийсэн.

Шинээр ажилд орсон ажилтнуудад явуулах сургалтын хөтөлбөрт Архидан согтуурахын эсрэг, ГХУС хууль тогтоомжийн сургалт явуулж байна.

Компанийн дэргэдэх “Ургах наран” АА бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор сумын АА бүлэгтэй нэгтгэн хамтран ажиллаад тодорхой хугацаа өнгөрсөн. Үүний үр дүнд тус байгууллагаас нийт 12 ажилтан архинаас бүрэн татгалзаад зөгсохгүйгээр архины хор хөнөөлийн талаар хамт ажилладаг ажилтнууддаа яриа таниулга хийж хэвшсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажлын хүрээнд хийсэн нэг олзуурхах ажил бол сумын хүүхэд багачуудад гэмт хэргийн тухай хуулийн талаар мэдлэг олгох, сурагчдыг сургуулийн орчинд аливаа халдлага эрсдлээс

өөрийгөө болон бусдыг хамгаалах, энэ чиглэлд сурагчид болон нийгмийн ажилтан нарын үүрэг оролцоо, идэвхийг өрнүүлэх зорилгоор 3-р ахлах сургуулийн 9-12-р ангийн сурагчдын дунд "ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" сэдэвт "ДЭВЖЭЭ" тэмцээнийг зохион байгуулсан. Цаашид энэхүү арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Хэсэг нэгжийн ажилтнуудыг аюулгүй ажиллагааны арга барилд сургах зорилгоор 355 ажилтанд 614 цагийн сургалт, шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөх нийт 173 ажилтанд мэргэжлийн чиг баримжаа олгох, дагалдангийн хугацааны анхан шатны сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, мэргэжил сургалтын комисс бүрдүүлж шалгалтыг авч мэргэжлийн ажилд жинхлүүлэх ажлыг гүйцэтгэсэн байна.

Уурхайчдын бие даан сурч хөгжих боломжоор хангах, орчинг бүрдүүлэх, мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор мэдээллийн санг ажиллуулж байна. Мэргэжлийн, аюулгүй ажиллагааны, ур чадварын зэрэг 3 чиглэлээр 580 гаруй номын фондтой болж ажилтан бүрт уншлагын картыг нээн ажиллаж байна.

Уурхайн үйлдвэрлэлийн баазыг түшиглэн их дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллаж нэн шаардлагатай байгаа мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг шилж сонгох, шалгаруулж авах бодлогын хүрээнд оюутан сурагчдад үйлдвэрлэлийн дадлага хийхэд нь арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж ажилласан. 2014 онд Улаанбаатар хотын "ШУТИС" – 42, Дархан хотын "ШУТИС" - 28, "Газарчин дээд сургууль" - 35, "Монголын үндэсний дээд сургууль" - 21, "Таван ач" сургалтын төв - 35, Говьсүмбэр аймаг дахь "Техникийн коллеж" - 65 оюутан буюу нийт 226 оюутан Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд үйлдвэрлэлийн дадлагыг удирдамжийн дагуу хийсэн.

Компанийн сургалтын тасгаас зохион байгуулсан гадаад сургалтуудаас "Политехникийн коллеж"-ийн чадамжийн зориулалтаар хийсэн 8 лабораторын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлахад 30 инженер техникийн ажилтан, засварын хэсгийн нийт 22 ажилтан хамрагдсан байна. Мөн ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн машин үйлдвэрлэлийн тэнхимийн доктор (Ph.D) О.Галаа багш хэлтэс, хэсгийн механик инженер, засварын хэсгийн токарьчид нийлсэн 13 ажилтанд "Хэмжил зүйн" хичээлээр сургалт явуулсан. Говьсүмбэр аймгийн "Политехникийн коллеж"-ийн сургуультай хамтран "Цахилгаан механикийн техникч" мэргэжил эзэмшүүлэх зорилгоор бямба, ням гарагт сургалт зохион байгуулж 23 ажилтны сурах боломжийг бүрдүүлсэн.

Ахмаднастны нийгмийн хамгаалалд жил бүр сар шинийн баяр, ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэн "Халзан уул" рашаан сувилалд 5 хоног амрааж, нүүрсний үнийн хөнгөлөлт зэргийг олгосон. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын дагуу /25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага/ хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнийг ажиллуулахаас 15 ажилтан ажиллаж байгаа.

Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг ИТА нарын дунд зохион байгуулах арга хэмжээг 2014 оны хувьд шинэлэг байдлаар зохион байгуулсан.

2014 оны 12 дугаар сарын сүүлээр өөрийн хөрөнгөөр 12-р байрны засварын ажлыг эхлүүлэхээр тендер зарлан гэрээгээ байгуулан ажиллаж байна. 2014 онд орон сууцны хангамжийн асуудлаар 48 уурхайчинд орон сууц олгож, 32 уурхайчны орон сууцны нөхцөлийг сайжруулсан.

Тус компани 2014 онд иргэд болон ажилтнуудаас нийт 502 өргөдөл хүлээн авч хуульд заасан хугацаанд 379 өргөдөл буюу 75 %-ийг шийдвэрлэсэн.

2014 онд нийт 18 ажилтныг төрийн одон медаль болон аймаг, сумын шагналд тодорхойлон 12 ажилтан нь шагнал авсан байна. Эдгээрээс Монгол улсын Хөдөлмөрийн хүндэт медаль-1, Тэргүүний уурхайчин-8, Эрчим хүчний тэргүүний ажилтан-1, Шивээговь сумын тэргүүний ажилтан-1, Засаг даргын баярын бичгээр-1 тус тус шагнагдсан.

## **ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Тус компанийн 2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөр нийт 96 нэр төрлийн 56,673,855.5 мян.төгрөгийн худалдан авалт тусгагдсанаас гүйцэтгэлээр 29,005,324.8 мян.төгрөг худалдан авалт хийсэн.

34,836.3 сая төгрөгийн 36 нээлтэй тендер шалгаруулалт хийжээр төлөвлөгдснөөс 31,795.0 сая төгрөгийн дүн бүхий 25 нээлттэй тендерийг амжилттай зохион байгуулж ажилласан. 836,2 сая төгрөгийн харьцуулалтын худалдан авалт 931,3 сая төгрөгийн шууд худалдан авалт хийж гүйцэтгэсэн.

Үлдэж байгаа 11 ажлын 3 нь гэрээ байгуулагдсан, 8 ажил тендер зарлагдаагүй болно.

Гэрээ байгуулагдсан нь:

Бульдэзер, Хатаах үйлдвэр, шулуун конвейерийн байгууламжийн 1 бутлуурын эх үүсвэрийг салгах ажил, Орон сууцны байрны караказ шинээр засварлаж ашиглалтанд оруулах ажлууд байна.

2. Худалдан авалт зохион байгуулагдаагүй:

- Хөнгөлтэй зээлийн хөрөнгөөр санхүүжих хөрсний конвейер 15,500,000 мян.төгрөг
- Цахилгаан гидро-экскаватор 900,900 мян.төг
- Хөдөлгүүр засвар үйчилгээний төв /технологийн автомашинуудад/ 682,745.0 мян.төг
- Технологи дамжлагын хэсгийн сэлбэг материал 227,750.0 мян.төг
- Хатаах үйлдвэрийн сэлбэг 153,643.3 мян.төг
- Хавтан тэжээгч сэлбэг /угсралт/ 289,738.0 мян.төг
- Нүх сэргээх ажил 60,000 мян.төг



### ТАВ.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2014 оны бизнес төлөвлөгөөгөөр нийт 36,556.5 сая төгрөгийн борлуулалт хийж 43,739.9 сая төгрөгийн зардал гарган 7,183.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн юм.

2014 онд үндсэн үйл ажиллагаанаас 36,163.6 сая төгрөгийн орлого олж 40,682.7 сая төгрөгийн зардал гарган 4,519.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанаас 552.6 сая төгрөгийн орлого олж 1026.5 сая төгрөгийн зардал гарган 473.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллан, нийт дүнгээрээ 4,993.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаа.

Төлөвлөгөөт алдагдалыг 2.2 тэрбум төгрөгөөр бууруулсаныг задалж тайлбарлавал:

1. Үйлдвэрлэлийн зардал үнийн хэмнэлтээр 1.9 тэрбум төгрөг
2. Зардлын биет хэмнэлтээр 3.7 тэрбум төгрөг,
3. Оператор компани ажиллуулж 1038.6 мянган м3 тээвэртэй хуулалтыг нэгжийн өртгийг 27.0 хув бууруулснаас үүссэн 745.9 сая төгрөгийн хэмнэлт,
4. Ажлын хөлс, татвар зэрэг зардлын үнийн дүнгээрх хэтрэлт 4.4 тэрбум төгрөг
5. Төлөвлөгөөт нүүрс олборлолт, хөрс хуулалтын ажлаа дутуу хийснээс үүссэн 825.6 сая төгрөгийн хэмнэлт
6. Илчлэгээс шалтгаалан алдсан борлуулалтын орлогын бууралт 524,0 сая төгрөг зэрэг болно.

Ингээд нийт, алдагдлыг  $1,9+3,7+0,745-4,4-0,5=2.2$  / 2.2 тэрбум төгрөгөөр бууруулсан.

Өнгөрсөн оны мөн үед 1917.0 мян.тн нүүрс борлуулж 34,215.9 сая төгрөгийн зардал гаргаж нэгжийн өртөг 17,848.5 төгрөг байсан бол 2014 онд 40,682.8 сая төгрөгийн зардал гаргаж нэгжийн өртөг 20,203.3 төгрөг болсон.

Өөрөөр хэлбэл өмнөх оны мөн үеэс нэгжийн өртөг 13.2 хувь буюу 2354.8 төгрөгөөр өссөн.

### НҮҮРС БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААР

2014 онд 2,013.7 мянган тонн нүүрс борлуулж төлөвлөгөөгөө 0.7 хувиар давуулан биелүүлээд байна. Нүүрс борлуулалтын орлого 36163.6 сая төгрөг байлаа.

ДЦС-4 компанид нийлүүлсэн нүүрсний жилийн дундаж илчлэг 2980.4 ккалори/кг буюу нийлүүлэх нүүрсний стандарт илчлэг 3030 ккал/кг нийт дүнгээрээ 524.1 сая төгрөгийн олох боломжоо алдсан байна. 2014 оны 1-р улирлын байдлаар Олборлосон нүүрсний дундаж илчлэг 2928.0 ккал/кг, 2-р улиралд 2974.7 ккал/кг, 3-р улиралд 3060.0 ккал/кг, 4-р улиралд 2959.0 ккал/кг гарсан байна.

Нийт нүүрснийхээ 97.7 хувийг доорх 7 хэрэглэгчид борлуулсан байна.

Нүүрс борлуулалтын зах зээлийн томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй нүүрсний хэмжээг үзүүлбэл / мянган тонноор /

ДД/д	Хэрэглэгчид	2013 оны гүйцэтгэл	2014 оны төлөвлөгөө	2014 оны гүйцэтгэл	Дүнд эзлэх хувийн жин
1.	ДЦС-IV ТӨХК	1747.6	1750.0	1831.4	90.9
2.	УБ Төмөр зам	50.3	60.0	36.5	1.8
3.	Бор өндөр УБУ	40.3	50.0	37.7	1.9
4.	Дорноговь ЭХНУ	38.1	41.3	33.7	1.7
5.	Цагийн аяс ХХК	6.9	0	0	0
6.	Төв Чандмань ЭХНУ	6.7	6.0	3.8	0.2
7.	Сэлэнгэ Энерго	1.468	6.0	0	0
8.	Налайх ДС	0	0	20.7	1.0
9.	Говьсүмбэр	10,3	12.7	3.8	0.2
10.	УС-15 ДС	0	50.0	0	0
11.	Бусад	15.3	24.0	46.1	2.3
12.	Дүн	1917.0	2000.0	2013.7	100.0

2014 оны байдлаар манай нүүрс борлуулалтын зах зээлд шинэ томоохон хэрэглэгч нэмэгдсэнгүй.

#### ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРТӨГ ЗАРДЛЫН ТАЛААР

2014 оны гүйцэтгэлээр нүүрс борлуулалтын нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 5.8 хувь буюу 2,527.2 сая төгрөгөөр хэмнэгдэж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 18.9 хувиар буюу 6,466.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт гарч байна.

Энэ хугацаанд нэг тонн нүүрсийг 20,203.3 төгрөгөөр олборлон 17959.1 төгрөгөөр борлууллаа. Нүүрс борлуулалтын нэгж тутмаас 2244.2 төгрөгийн алдагдал хүлээж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1 тонн нүүрсний өртөг 2354.8 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн уулын цулын нэгжийн өртөг төлөвлөсөн хэмжээнээс 3.3 хувь буюу 115.7 төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеийн түвшингөөс 388.7 төгрөгөөр өссөн юм.

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй нийт зардлаас төлөвлөсөн хэмжээнээс 14 нэр төрлийн зардал 8,135.5 сая төгрөгийн хэмнэлттэй гарч, 5 нэр төрлийн зардал 4410.2 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй гарч дүнгээрээ 3,725.3 сая төгрөгөөр зардал хэмнэсэн байна.

Төлөвлөгөөнөөс хэтэрсэн болон хэмнэсэн зардлуудын талаар санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тайлбарлах болно.

**АВЛАГА ӨГЛӨГИЙН ТАЛААР**

Компанийн нийт авлага 2014 онд 7650,5 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 52,4 хувь буюу 2632,1 сая төгрөгөөр өссөн. Энэ өсөлт ДЦС-4 ТӨХК-аас авах авлагын өсөлт юм. ДЦС-4 ТӨХК-аас 5407,5 сая, бусад төрийн болон орон нутгийн өмчит станцуудаас 905,3 сая төгрөгийн авлагатай байгаа нь нийт авлагын 82 хувь болж байна.

Богино хугацаат өглөг 2014 онд 31624,1 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 17,8 хувь буюу 4775,8 сая төгрөгөөр өссөн. Сангийн яаманд төлөх хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн өглөг 5375,4 сая төгрөгөөр өс харин бусад өглөгийг 599,6 сая төгрөгөөр бууруулсан.

Засгийн газар, Сангийн яамны шийдвэрээр НИК, Петровис тос, Содмонгол компаниудад өгөх өглөг 2.4 тэрбум төгрөг, АМНАТ татвар, НӨАТ татвар, 3 жилийн талбай ашигласны хөлс 2.2 тэрбум төгрөг нийт 4.6 тэрбум төгрөгийн өрийг хаалтаар хойшлуулсан нь компанийн төлбөрийн чадвард эерэг нөлөөтэй чухал ажил болсон.

Тус компани нь санхүү болон худалдан авалтын үйл ажиллагаандаа "Шилэн дансны хууль"-г хэрэгжүүлэх бэлтгэлийг 2014 оны 11-12-р саруудад хангаж, 2015 оны 1-р сарын 1-нээс уг хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Өнгөрсөн онтой харьцуулахад цалингийн зардал 1,4 тэрбум төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдэл 1,6 тэрбум төгрөг, татвар 0,3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Эдгээр нөлөөлөлийг хасан тооцвол /4,9-3,3=1.6/ 2014 онд 1.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ гэж дүгнэхээр байна.**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 3-р сарын 18-ны хурлаар компанийн 2014 оны үйл ажиллагааг хэлэлцэж хангалттай гэж дүгнэсэн юм.

- 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр
- Компанийн эргэлтийн хөрөнгийн дүн .261914,2 сая төгрөг
- Түүний дотор мөнгөн хөрөнгийн дүн 1221,4 сая төгрөг..
- Авлага 7611,8 сая төгрөг
- Бараа материал 13217,3 сая төгрөг

Эргэлтийн бус хөрөнгийн дүн 69903,1 сая төгрөг нийт хөрөнгийн дүн 69903,1 сая төгрөг байсан болно.

- Эх үүсвэрийн хувьд
- Богино хугацаат өглөг 31271,0 сая
- Урт хугацаат өглөг 55378.9 сая
- Тайлант жилийн алдагдал 4986,3 сая
- Нийт эх үүсвэрийн дүн 96084,3-сая төгрөг байлаа.

Ингээд дээрх үзүүлэлттэй санхүүгийн тайланг баталж өгөхийг хувьцаа эзэмшигчид та бүхнээс хүсч байна.



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2015.03.24 № 9/ССЭ  
ганай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

- Тус компанийн үүсгэн байгуулсан 100%-ийн эзэмшлийн "Шивээ сервис" ХХК-ийн санхүүгийн тайланг толгой компани болох "Шивээ-Овоо" ТӨХК-ийн санхүүгийн тайланд нэгтгэж тайлагнаагүй нь СТОУС-10-д "Толгой компани болох аж ахуйн нэгж нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулна" гэснийг зөрчиж байгаа нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол "Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

**"ШИВЭЭ-ОВОО" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2014 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН  
АУДИТЛАГДСАН ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ**

**ХӨРӨНГӨ**

	/төгрөгөөр/	
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>2013.12.31</b>	<b>2014.12.31</b>
Мөнгөн хөрөнгө	3,216,339,672.50	1,121,094,638.57
Авлага	5,004,177,881.76	7,605,318,611.46
Татвар, НДШ-ын авлага	14,239,994.40	6,632,000.00
Бараа материал	14,662,869,173.36	13,177,100,870.67
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	2,589,969,443.10	2,864,464,789.52
Хөрөнгө оруулалтын тооцоо	1,276,065,060.00	1,276,065,060.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>26,763,661,225.12</b>	<b>26,050,675,970.22</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
Үндсэн хөрөнгө	65,356,538,714.89	68,779,440,351.19
Биет бус хөрөнгө	630,074,112.00	579,564,112.00
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	696,965,400.36	846,965,400.36
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>66,683,578,227.25</b>	<b>70,205,969,863.55</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>93,447,239,452.37</b>	<b>96,256,645,833.77</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ</b>		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Давсны өглөг	16,350,710,619.86	25,124,585,066.29
Цалингийн өглөг	197,941,046.72	217,861,063.79
Татварын өр	289,050,555.90	320,932,699.63
НДШ-ийн өглөг	244,691,991.11	790,047,135.50
Банкны богино хугацаат цээл	9,758,464,085.44	4,675,891,992.93
Хүүний өглөг		
Урьдчилж орсон орлого	99,331.80	
Нөөц өр		
Бусад богино хугацаат өр төлбөр	7,388,981.90	41,425,898.00
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>26,848,346,612.73</b>	<b>31,170,743,856.13</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Урт хугацаат зээл	53,711,878,146.36	55,378,950,546.00
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>53,711,878,146.36</b>	<b>55,378,950,546.00</b>
<b>ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>		
а/ Төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00
б/ Хувийн	134,190,000.00	134,190,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,329,391,486.40	20,329,391,486.40
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	(8,784,276,793.12)	(8,784,276,793.13)
тайлант үе	(2,998,169,732.04)	(4,986,313,304.97)
өмнөх үе	(5,786,107,061.08)	(6,978,026,749.79)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>12,887,014,693.28</b>	<b>9,706,951,431.64</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР ӨМЧИЙН ДҮН</b>	<b>93,447,239,452.37</b>	<b>96,256,645,833.77</b>

**"ШИВҮҮЭ-ОВОО" ӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУССАВАР БОЛСОН  
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	2013.12.31	/төгрөгөөр/ 2014.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	29,281,270,864.00	27,953,636,494.38
Борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	28,902,056,744.00	27,282,232,093.00
Туслах үйл ажиллагаанаас орсон орлого	341,856,370.00	566,563,833.38
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	37,357,750.00	104,840,568.00
Мөнгөн зарлагын дүн	35,607,828,326.40	33,663,535,994.24
Ажиллагсад олгосон мөнгө	4,506,703,840.00	6,556,945,226.08
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	1,104,942,657.20	1,105,000,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	24,029,361,694.10	16,562,932,310.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	2,554,969,739.76	5,870,344,480.34
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	167,777,870.64	246,908,640.00
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	44,756,586.96	254,224,477.13
Татварын байгууллагад төлсөн мөнгө	2,467,771,050.74	2,089,915,853.00
атгалын төлбөрт төлсөн мөнгө	154,605,735.00	-
бусад мөнгөн зарлага	576,939,152.00	977,265,007.69
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(6,326,557,462.40)</b>	<b>(5,709,899,499.86)</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	74,837,968.00	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	74,837,968.00	-
Мөнгөн зарлагын дүн	<b>(2,012,853,771.50)</b>	<b>150,000,000.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	2,012,853,771.03	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	150,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	<b>(1,938,015,803.50)</b>	<b>(150,000,000.00)</b>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн )	12,587,232,044.22	5,454,000,000.00
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	12,580,000,000.00	5,454,000,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,232,044.22	-
Мөнгөн зарлагын дүн	<b>(2,232,140,602.00)</b>	<b>1,689,345,534.08</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	<b>(2,112,147,273.00)</b>	<b>1,645,192,172.00</b>
Төрөл бүрийн хандив	<b>(115,433,055.00)</b>	<b>44,142,127.90</b>
Валютын ханшийн зөрүүгийн гарз	<b>(4,560,274.00)</b>	<b>11,234.18</b>
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>10,355,091,442.22</b>	<b>3,764,654,465.92</b>
ух цэвэр мөнгөн гүйлгээ	<b>2,090,518,176.32</b>	<b>(2,095,245,033.94)</b>
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,125,821,496.19	3,216,339,672.51
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,216,339,672.51	1,121,094,638.57

**"ШИВЭЭ-ОРОО" ТӨРИЙН ӨМЧИГ ХУВЬЦАА КОМПАНИЙН  
2014 С. АЛ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН  
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Хэүүлэлт	Өмч	Халаасын хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуригтлагдсан ашиг	Нийт дүн	/төгрөгөөр/
2013 оны 01-р сарын 01-ээрх үлэгдэл	1,341,900,000.00	-		20,271,950,623.80	(5,571,049,077.11)	16,042,801,546.69	
Нягтлан болох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(215,057,983.98)	(215,057,983.98)	
Залруулсан үлдэгдэл					(5,786,107,061.09)	(5,786,107,061.09)	
Тайланг үеийн нэвэр ашиг /алдагдал/					(2,998,169,732.04)	(2,998,169,732.04)	
Бусад дэлгэрэнгүй орлого				57,440,862.61		57,440,862.61	
Өмчид гарсан өөрчлөлт							
Зарласан ноогдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,341,900,000.00			20,329,391,486.41	(8,784,276,793.13)	12,887,014,693.28	
Нягтлан болох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					1,806,250,043.33	1,806,250,043.33	
Залруулсан үлдэгдэл					(6,978,026,749.80)	(6,978,026,749.80)	
Тайланг үеийн нэвэр ашиг /алдагдал/					(4,986,313,304.97)	(4,986,313,304.97)	
Бусад дэлгэрэнгүй орлого							
Өмчид гарсан өөрчлөлт							
Зарласан ноогдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,341,900,000.00			20,329,391,486.41	(11,964,340,054.77)	9,706,951,431.64	



**"ШИНВЭЭ-ОВОО" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН  
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН**

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.12.31	2014.12.31
Борлуулалтын орлого /цэвэр/	31,608,061,073.06	36,163,584,468.44
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	28,153,811,378.27	33,009,093,204.00
<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>3,454,249,694.79</b>	<b>3,154,491,264.44</b>
Түрээсийн орлого	672,727.28	
Хүүний орлого	90,278,558.80	102,564,885.38
Бусад орлого	781,739,812.57	453,381,708.78
Борлуулалт, маркетингийн зардал	4,670,360,835.61	5,838,186,442.98
Ерөнхий удирдлагын зардал	1,391,687,648.86	1,832,276,482.18
Бусад зардал	1,258,618,578.32	1,026,288,238.41
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	(4,443,462.70)	
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(2,998,169,732.04)</b>	<b>(4,986,313,304.97)</b>
12. Орлого татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(2,998,169,732.04)	(4,986,313,304.97)
Цөөнхөд ноогдох хувь		
Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	(2,998,169,732.04)	(4,986,313,304.97)
9. Онцгой шинжтэй зүйлс- цэвэр		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,998,169,732.04)	(4,986,313,304.97)
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)		